

БАТЛАВ.
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК-НЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ч.АМАРСАНАА
2016.03.____

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Э-Транс ложистикс хувьцаат компанийн / цаашид Компани гэнэ / ажилчдийн ажил, албан үүргээ гүйцэтгэх үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Компани нь ажилчин бүрт энэхүү дүрмийг дагаж мөрдүүлэх бөгөөд байнгын хяналт, хариуцлагын тогтолцоог дотооддоо бүрдүүлж ажиллана.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэхүү дүрэм нь Компанид ажиллаж байгаа нийт ажилчидаас гадна гэрээний дагуу хамтран ажиллаж байгаа гэрээт харуул хамгаалалтын албанд мөн хамаарна.

Гурав. Ёс зүйн зарчим

3.1. Компанийн ажилчид үйл ажиллагаандаа дор дурьдсан ёс зүйн зарчмыг чанд баримтална.

- шударга ёсны;
- хууль дээдлэх;
- ялгаварлан гадуурхахгүй байх;
- хариуцлага хүлээх;
- үйлчлүүлэгчдэд эрх тэгш үйлчилэх,

Дөрөв. Ёс зүйн эрхэмлэн дээдлэх зүйлс

4.1. Компанийн нийт ажилчид нь энэхүү дүрмийн 3.1-д заасан зарчмын хүрээнд компанийн эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэхдээ дор дурдсан зүйлсийг эрхэмлэн дээдэлнэ:

4.1.1. шударга ёсны зарчмын хүрээнд: хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байх;

4.1.2. хууль дээдлэх зарчмын хүрээнд: үйл ажиллагаандаа мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм зааврыг чанд мөрдөж ажиллах болон бусад хуулийг ямагт дээдлэн сахих;

4.1.3. тэгш байдлын зарчмын хүрээнд: ажилчин бүр өөр хоорондоо адил тэгш, алагчлалгүй харьцан Компанийн хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах;

4.1.4. хариуцлага хүлээх зарчмын хүрээнд: ажил үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн мэдлэг чадварыг байнга дээшлүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;

4.1.5 олон нийтэд үйлчлэх зарчмын хүрээнд: компанийн үйлчилгээг олон нийтэд чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой харьцаж, тэдний итгэлийг хүлээж ажиллах.

Тав. Ёс зүйн хэм хэмжээ

5.1. Компанийн нийт ажилчид нь энэхүү дүрмийн 4.1.1-д заасаан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурьдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

5.1.1. Хөдөлмөрийн хууль, Компанийн хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг бүрэн, үр бүтээлтэй ашиглах;

5.1.2. үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх;

5.1.3. Компанийн зорилго, зорилт, ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах;

5.1.4. албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх харилцагч иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс шан харамж, зээл авах, хууль бус бусад хангамж эдлэхгүй байх.

5.2. Компанийн нийт ажилчид нь энэхүү дүрмийн 4.1.2-д заасаан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд до дурьдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

5.2.1. Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, Компанийн хэмжээнд дагаж мөрдөж байгаа дэг журам, дүрэм, зааврыг чанд баримтлах;

5.2.2. хууль зөрчсөн, эрхэлж байгаа албан тушаалын байдлаа урвуулан ашигласан болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага / ТУЗ /, гүйцэтгэх удирдлагад мэдээлэх;

5.2.3. албан үүргээ гүйцэтгэж байхдаа Компанийн болон хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байж, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглах, Компанийн дотоод мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх;

5.2.4. Компанийн эд хөрөнгө, техник хэрэгсэл, дотоод мэдээллийг албаны бус зорилгоор ашиглахгүй байх.

5.3. Компанийн нийт ажилчид нь энэхүү дүрмийн 4.1.3-т заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

5.3.1. удирдах ажилтан нь албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгч, хамтран ажиллагсадтайгаа эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх;

5.3.2. иргэд, үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлэх, ажиллагсад хоорондоо харилцахдаа хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;

5.3.3. танил тал, найз нөхөд, гэр бүл, төрөл садангийн хүмүүсийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг цээрлэх;

5.3.4. албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгахыг хориглох;

5.3.5. бусад ажилчдын үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардах, үүрэг даалгавар өгөхийг хориглох.

5.4. Компанийн нийт ажилчид нь энэхүү дүрмийн 4.1.4-т заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

5.4.1. өөрийн мэдлэг чадвар, дадал туршлагаа байнга хөгжүүлж, өөрийн ажил, албан тушаалын нэр хүндийг байнга дээдлэх;

5.4.2. ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг биечлэн хангах;

5.4.3. удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагавар, сөрөг талыг урьдчилан анхааруулж байх;

5.4.4. захирах, захирагдах ёсны зарчмыг баримталж, тодорхой асуудлаар өөр саналтай байсан ч удирдлагаас гаргасан хуульд нийцсэн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;

5.4.5. албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, этгээд байдлаар хувцаслах, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэх;

5.4.6. компанийхаа зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар удирдлагаас явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн мэдээ, мэдээлэл тараахгүй байх.

5.5. Компанийн нийт ажилчид нь энэхүү дүрмийн 4.1.5-д заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

5.5.1. үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх;

5.5.2. энэхүү ёс зүйн дүрмийг баримтлан иргэдтэй төлөв төвшин харилцах;

5.5.3. иргэдэд үзүүлэх ачаа тээврийн үйлчилгээг зохих байгууллагаас баталсан дүрэм, журмын дагуу цаг алдалгүй, ялгаварлалгүй ил тод, түргэн шуурхай хүргэх.

__оОо__